



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жинст сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/137/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК

Захирал Г.Саранчимэг

Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Аудитор: О.Мандах

Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	3
<b>Аудитын гол асуудал</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ .....	9
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	14
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	14
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асууда</b> ....	14
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	15
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	15
<b>Байхгүй</b> .....	15
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУ С	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



Г ЖИНСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА ЦЭРЭНХҮҮ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/40

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 49/A/119 дугаар тушаал, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцон гүйцэтгэлээр санхүүжиж Эрүүл мэндийн даатгалын сангаас 513,793.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 32,266.9 мянган төгрөгийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг мөрдсөн байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

5020168

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.6 хувьтай тайлагнаж дээд шатны байгууллагаас 92,9 хувьтай дүгнэсэн байна.

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>134,134,710.56</b>	<b>104,907,054.39</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	54,079,461.00	32,266,977.93
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	54,079,461.00	32,266,977.93
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	54,079,461.00	32,266,977.93
31211	Төрийн сангийн харилцах	54,079,461.00	32,266,977.93
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	10,672,287.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	10,672,287.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	80,055,249.56	61,967,789.46
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	69,148,691.56	49,460,159.46
35110	Тусгай зориулалттай материал	48,579,845.87	40,648,450.96
35130	Эм боох материал	20,568,845.69	8,811,708.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,906,558.00	12,507,630.00
35420	Аж ахуйн материал	4,974,208.00	4,801,280.00
35470	Бусад хангамжийн материал	5,932,350.00	7,706,350.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>705,046,046.61</b>	<b>1,429,310,677.64</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	705,046,046.61	1,429,310,677.64
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	702,037,380.07	1,426,346,011.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	599,691,382.86	1,350,112,398.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,364,346.18	-63,082,123.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	52,765,000.00	52,765,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,922,639.07	-27,607,472.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,043,112.86	205,169,571.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-102,341,648.82	-114,516,509.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,767,445.02	54,366,445.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,980,926.60	-31,971,298.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,695,070.00	2,337,271.86
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,615,070.00	-1,527,271.86
39217	Ном	300,000.00	300,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,008,666.54	2,964,666.50
39301	Програм хангамж	670,000.00	670,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-589,333.46	-633,333.50
39303	Бусад биет бус хөрөнгө	2,928,000.00	2,928,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>839,180,757.17</b>	<b>1,534,217,732.03</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>839,180,757.17</b>	<b>1,534,217,732.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	839,180,757.17	1,534,217,732.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	295,911,043.12	295,911,043.12
51101	Өмч: - төрийн	295,911,043.12	295,911,043.12
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	167,962,635.24	864,069,301.89
51210	Өмнөх үеийн үр дүн	167,962,635.24	169,032,327.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	695,036,974.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	375,307,078.81	374,237,387.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>839,180,757.17</b>	<b>1,534,217,732.03</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

БНА-2024/137/НА-СТА-ТШЗ



**Жинст сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>643,784,678.28</b>	<b>1,354,476,578.98</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>161,666,187.28</b>	<b>784,419,853.12</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	161,666,187.28	784,419,853.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	113,279,553.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	113,279,553.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>482,118,491.00</b>	<b>570,056,725.86</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,280,411.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,604,970.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	37,025,100.00	45,590,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,025,100.00	45,590,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	432,812,980.00	524,465,925.86
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	432,812,980.00	524,465,925.86
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>625,542,438.50</b>	<b>657,289,261.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>625,542,438.50</b>	<b>657,289,261.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	623,101,886.50	657,143,316.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	319,081,413.00	392,429,171.73
210101	Үндсэн цалин	209,052,719.00	258,634,035.68
210102	Нэмэгдэл	75,541,627.00	92,002,501.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,730,000.00	4,501,000.00
210104	Урамшуулал	29,757,067.00	37,291,635.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,521,575.00	48,308,708.00
210201	Тэтгэврийн даатгал	40,521,575.00	48,308,708.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,584,548.00	42,044,855.00
210301	Гэрэл, цахилгаан	4,069,383.00	5,552,797.00
210302	Түлш, халаалт	29,810,165.00	35,772,058.00
210303	Цэвэр, бохир ус	705,000.00	720,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,003,850.00	56,634,865.36
210401	Бичиг хэрэг	3,543,950.00	2,810,700.00
210402	Тээвэр, шатахуун	20,382,050.00	20,217,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,988,250.00	1,980,000.00
210404	Ном, хэвлэл	175,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,996,800.00	2,142,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,917,800.00	4,025,410.51
210408	Бараа материал акталсны зардал	00.00	25,459,304.85
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	46,388,492.16	49,690,214.54
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,426,832.16	42,354,264.54
210502	Хоол, хүнс	8,556,660.00	7,335,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	405,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,257,000.00	4,301,700.00
210604	Урсгал засвар	5,257,000.00	4,301,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,344,000.00	1,674,000.00

БНА-2024/137/НА-СТА-ТШЗ



Жинст сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	2,344,000.00	1,674,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>78,055,349.00</b>	<b>190,205.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,747,849.00	190,205.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,500.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,865,659.34</b>	<b>61,869,596.72</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,994,044.00	6,534,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,871,615.34	55,335,256.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,440,552.00</b>	<b>145,945.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,440,552.00</b>	<b>145,945.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,440,552.00	145,945.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>18,242,239.78</b>	<b>697,187,317.63</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>2,150,342.77</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,220,222.45
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	930,120.32
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-2,150,342.77</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>18,242,239.78</b>	<b>695,036,974.86</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>767,551,044.00</b>	<b>559,384,438.86</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>654,271,491.00</b>	<b>559,384,438.86</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>37,025,100.00</b>	<b>45,590,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,025,100.00	45,590,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>432,812,980.00</b>	<b>513,793,638.86</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	432,812,980.00	513,793,638.86
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>583,258,683.00</b>	<b>571,326,921.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>583,258,683.00</b>	<b>571,326,921.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>580,818,131.00</b>	<b>571,180,976.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>319,081,443.00</b>	<b>392,429,171.73</b>
210101	Үндсэн цалин	209,052,749.00	258,634,035.68
210102	Нэмэгдэл	75,541,627.00	92,002,501.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,730,000.00	4,501,000.00
210104	Урамшуулал	29,757,067.00	37,291,635.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>40,338,353.00</b>	<b>48,308,708.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,506,522.00	33,331,632.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,781,837.00	3,643,165.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,468,825.00	2,984,475.00

Жинст сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	598,160.00	767,909.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,983,009.00	7,581,527.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,584,548.00</b>	<b>42,044,855.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,069,383.00	5,552,797.00
210302	Түлш, халаалт	29,810,165.00	35,772,058.00
210303	Цэвэр, бохир ус	705,000.00	720,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,559,050.00</b>	<b>30,144,950.00</b>
210401	Бичиг хэрэг	3,543,950.00	2,758,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,382,050.00	20,217,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,988,250.00	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,965,000.00	1,999,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,504,800.00	3,190,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,004,416.00</b>	<b>46,734,892.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,044,316.00	37,878,942.20
210502	Хоол, хүнс	8,500,100.00	7,335,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,460,000.00	1,520,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,397,000.00</b>	<b>4,301,700.00</b>
210604	Урсгал засвар	5,397,000.00	4,301,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,344,000.00</b>	<b>1,674,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,344,000.00	1,674,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,569,410.00</b>	<b>5,542,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,569,410.00	5,542,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,440,552.00</b>	<b>145,945.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,440,552.00</b>	<b>145,945.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,440,552.00	145,945.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>184,292,361.00</b>	<b>-11,942,483.07</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>130,212,900.00</b>	<b>9,870,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>130,212,900.00</b>	<b>9,870,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>130,212,900.00</b>	<b>9,870,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	130,212,900.00	9,870,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-130,212,900.00</b>	<b>-9,870,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>54,079,461.00</b>	<b>-21,812,483.07</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>54,079,461.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>54,079,461.00</b>	<b>32,266,977.93</b>

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,911,043.12	375,307,078.81	-70,436,433.54	600,781,688.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>295,911,043.12</b>	<b>375,307,078.81</b>	<b>-70,436,433.54</b>	600,781,688.39
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,284,361.51	6,284,361.51
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,911,043.12	375,307,078.81	167,962,635.24	839,180,757.17
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,911,043.12	375,307,078.81	167,962,635.24	839,180,757.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,069,691.79	1,069,691.79
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>295,911,043.12</b>	<b>375,307,078.81</b>	<b>169,032,327.03</b>	840,250,448.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,069,691.79	00.00	-1,069,691.79
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	695,036,974.86	695,036,974.86
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,911,043.12	374,237,387.02	864,069,301.89	1,534,217,732.03

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	706,737,900.0	581,050,976.9	125,686,923.1	82.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	706,737,900.0	581,050,976.9	125,686,923.1	82.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	706,737,900.0	581,050,976.9	125,686,923.1	82.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,410,500.0	392,429,171.7	87,981,328.3	81.7
210101	Үндсэн цалин	314,052,500.0	258,634,035.7	55,418,464.3	82.4
210102	Нэмэгдэл	113,925,500.0	92,002,501.1	21,922,999.0	80.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.0	4,501,000.0	1,307,000.0	77.5
210104	Урамшуулал	46,624,500.0	37,291,635.0	9,332,865.0	80.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,051,400.0	48,308,708.0	11,742,692.0	80.4
210201	Тэтгэврийн даатгал	40,834,900.0	33,331,632.0	7,503,268.0	81.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,804,200.0	3,643,165.0	1,161,035.0	75.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,843,300.0	2,984,475.0	858,825.0	77.7
210204	Ажилгүйдлийн даатгал	960,800.0	767,909.0	192,891.0	79.9
210205	Эрүүл мэндийн даатгал	9,608,200.0	7,581,527.0	2,026,673.0	78.9

Жинст сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,190,800.0	42,044,855.0	145,945.0	99.7
210301	Гэрэл, цахилгаан	5,698,600.0	5,552,797.0	145,803.0	97.4
210302	Түлш, халаалт	35,772,200.0	35,772,058.0	142.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	720,000.0	720,000.0	00.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	38,215,900.0	30,144,950.0	8,070,950.0	78.9
210401	Бичиг хэрэг	3,819,500.0	2,758,500.0	1,061,000.0	72.2
210402	Тээвэр, шатахуун	24,380,000.0	20,217,000.0	4,163,000.0	82.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.0	1,980,000.0	36,000.0	98.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	1,999,450.0	550.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,400.0	3,190,000.0	2,810,400.0	53.2
2105	Нормативт зардал	54,888,000.0	46,734,892.2	8,153,107.8	85.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,253,400.0	37,878,942.2	4,374,457.8	89.6
210502	Хоол, хүнс	8,430,600.0	7,335,950.0	1,094,650.0	87.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,204,000.0	1,520,000.0	2,684,000.0	36.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,632,600.0	14,171,700.0	4,460,900.0	76.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.0	9,870,000.0	130,000.0	98.7
210604	Урсгал засвар	8,632,600.0	4,301,700.0	4,330,900.0	49.8
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.0	1,674,000.0	326,000.0	83.7
210702	Дотоод албан томилолт	2,000,000.0	1,674,000.0	326,000.0	83.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,348,700.0	5,542,700.0	4,806,000.0	53.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,348,700.0	5,542,700.0	4,806,000.0	53.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,590,800.0	45,444,855.0	145,945.0	99.7
132001	Орон нутгийн төсвөөс	45,590,800.0	45,444,855.0	145,945.0	99.7
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	607,067,700.0	513,793,638.9	93,274,061.1	84.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	607,067,700.0	513,793,638.9	93,274,061.1	84.6
1E+05	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	54,079,400.0	21,812,483.1	32,266,916.9	40.3
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	54,079,400.0	21,812,483.1	32,266,916.9	40.3
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	24.0	20.0	04.0	83.3
620001	Удирдах ажилтан	01.0	01.0	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17.0	13.0	04.0	76.5
620003	Үйлчлэх ажилтан	06.0	06.0	00.0	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жинст сумын Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн анхан шатны болон эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэн, хувь хүн хамт олны идэвхтэй оролцоонд тулгуурлан эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг

сайжруулахад оршино” гэсэн хүрээнд үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхойлсон байна.

Тус байгууллага нь Хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар хүртээмжтэй үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт тавин ажилласан байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд Эрүүл мэндийн төв нь 20 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант оны байдлаар нийт хэвтэн эмчлүүлэгсэд 229, дундаж ор хоног 6.5 хувь. эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 4926 хүн хамрагдаж үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 2163 хүн хамрагдсан эмчлүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Эрүүл мэндийн төвийн дарга Ц.Цэрэнхүү, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Төмөрбат нар зурж, нярваар Т.Оюунтөгс нар ажиллажээ.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 695.036.9 мянган төгрөгөөр буюу 82.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	54079.461	32267.0	-21,812.48
Авлага	00.00	10,672.29	0.00
Бараа материал	80,055.2	61967.78946	-18,087.46
Үндсэн хөрөнгө	912,860.01	1,668,648.69	755,788.68
хуримтлагдсан элэгдэл	-207,813.96	-239,338.01	-31,524.04
<b>Нийт хөрөнгө</b>	<b>839,180.76</b>	<b>1,534,217.73</b>	<b>695,036.97</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	839,180.76	1,534,217.73	695,036.97
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>839,180.76</b>	<b>1,534,217.73</b>	<b>695,036.97</b>

Эх сурвалж: Жинст сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 82,688.1 мянга, Эрүүл мэндийн газраас 13,469.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 85,036.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 3,750.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал шилжүүлж бараа материалын үлдэгдэл нь 18,087.4 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан байна.

Тайлант онд авлага 10,672.29 мянган төгрөгөөр шинээр авлага үүссэн нь ЭМД сангаас авах төлбөртэй үйлчилгээний авлага байна.

Төсвийн хөрөнгөөр 9,870.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг багаж техник хэрэгслийн зардлаас худалдан авсан, Эрүүл мэндийн газраас 14,037.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан, 756,912.2 мянган төгрөгийн өртөг бүхий амбулаторийн барилгыг ашиглалтад орж үндсэн хөрөнгө 755,788.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.



Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 сарын 13-ны өдрийн 13/08 тоот тогтоолоор 23,811.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Тайлант онд өмнөх оны өглөг төлөгдөж оны эцэст өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 695,036.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,534,217.7 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 695,036.9 мянган төгрөгөөр нэмэгдэж 864,069.3 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 694,472.2 мянга төгрөг, орон нутгийн төсвөөс 71,485.3 мянган төгрөг нийт 765,957.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс 182,586.7 мянган төгрөгөөр бууруулан 583,370.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлэхтэй холбоотой 1 удаа төсөвт өөрчлөлт оруулж 71,812.8 мянган төгрөгөөр тодотгож санхүүжилт нэмж олгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас 607,067.7 мянган төгрөг санхүүжилтийн төлөвлөгөө батлагдсан гүйцэтгэлээр 513,793.6 мянга, урьд оны санхүүжилтийн үлдэгдлээс 21,812.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,444.8 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 581,050.9 мянган төгрөгийг зарцуулж, 32,266.9 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталснаас 45,590.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.7 хувь буюу 45,444.8 мянган төгрөгийг зарцуулж 145.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
А	Хөтөлбөр 71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1	80302 Нэг иргэнд ноогдох нормативаар	387,881.3	352,083.8	35,797.5	90.8
2	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	219,186.8	151,128.4	68,058.4	68.9
3	83603 Нэмэлт-Дээд шатны төсвөөс	54,079.4	32,393.9	21,685.5	59.9
4	80112 Нийтлэг үйлчилгээ	45,590.8	45,444.9	145.9	99.7
	Дүн	706,738.3	581,051.0	125,687.3	82.2

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн захирал Г.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 зугаар улирлын нийт зардлын 628,135.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,281.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 4,711.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

##### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 553,731.7 мянган төгрөгийн 28 гүйлгээ, зарлагын 40,772.1 мянган төгрөгийн 8 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг "Номгон аудит" ХХК-ийн аудитор Г.Саранчимэг, аудиторын туслах Б.Оргилбаяр нар гүйцэтгэж, менежментийн захидлаар 1 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	100.00%
Нийт дүн	1	0	1	0	100.00%

*Эх сурвалж: Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2023.05.25-ны өдрийн 100 дугаар албан бичиг*

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.25-нй өдөр 100 дугаар албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил дутагдал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--

